

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: NazgulD@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны Захирал: Б.Галымбек Утас: 99426960 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/43/НА-СТА-ТШЗ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
9 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.АЛТЫН ТАНАА

2024.02.13 № 81
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402119

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34496847	162475162
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	780883	121443209
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	780883	121443209
3121	Төгрөг	780883	121443209
31211	Төрийн сангийн харилцах	780883	121443209
33	АВЛАГА	1314575	1309409
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1314575	1309409
35	БАРАА МАТЕРИАЛ	32401389	39722544
354	Хангамжийн материал	32401389	39722544
35410	Бичиг хэргийн материал	200000	399900
35440	Түлш, шатах тослох материал	93586	69586
35460	Хүнсний материал	5805319	5367074
35470	Бусад хангамжийн материал	26302484	33885984
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	706513218	719302932
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	706513218	719302932
391	Газар	13265000	13265000
392	Биет хөрөнгө	693248218	704772830
39201	Барилга, байгууламж, орон сууц	765050620	784950620
39202	Хуримтлагдсан элэгдэл	-85184735	-106449669
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20251275	31444475
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13135805	-16724830
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68013342	77013342
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64458260	-68172889
39217	Ном	2711781	2711781
393	Биет бус хөрөнгө	0	1265101
39301	Програм хангамж	550000	1973239
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000	-708138
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	741010066	881778094
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	772493
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	772493
413	Өглөг	0	772493
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	340493
4136	Бусад өглөг	0	432000
41361	Байгууллагад төлөх өглөг	0	432000
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	741010066	881005601
51	Засгийн газрын хувь оролцоо	741010066	881005601
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	146882958	146882958
51101	Өмч: - төрийн	146882958	146882958
512	Хуримтлагдсан үр дүн	592856272	732851807
51210	Өмнөх үеийн үр дүн	592856272	592856272
51220	Тайлант үеийн үр дүн	0	139995536
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1270836	1270836
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	741010066	881778094

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	598,893,100	975,400,739
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	21,779,239
120	Нийтлэг татварын бус орлого	-	21,779,239
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	21,779,239
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	21,779,239
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,893,100	953,621,500
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	525,289,100	905,885,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	525,289,100	905,885,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,500,500	47,736,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,500,500	27,836,400
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	19,900,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	616,767,978	835,405,203
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,767,978	835,405,203
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	616,380,112	835,405,203
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,773,142	595,549,110
210101	Үндсэн цалин	345,477,348	401,248,090
210102	Нэмэгдэл	71,581,300	172,756,456
210104	Урамшуулал	12,714,494	21,544,564
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,291,400	68,537,780
210201	Тэтгэврийн даатгал	36,918,200	44,888,360
210202	Тэтгэмжийн даатгал	4,343,600	6,165,800
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,474,700	4,189,000
210204	Ажилгүйдлийн даатгал	868,700	911,800
210205	Эрүүл мэндийн даатгал	8,686,200	12,382,820
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,157,563	27,127,893
210301	Гэрэл, цахилгаан	3,971,563	8,206,893
210302	Түлш, халаалт	14,830,200	16,471,000
210303	Цэвэр, бохир ус	2,355,800	2,450,000
2105	Нормативт зардал	69,112,001	99,094,145
210502	Хоол, хүнс	69,112,001	99,094,145
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,965,000	500,000
210604	Урсгал засвар	2,965,000	500,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	722,100	1,452,100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,100	1,452,100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,358,906	43,144,175
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,690,571	9,850,900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,184,600	4,566,550

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,483,735	28,726,725
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	387,866	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	387,866	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	387,866	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,874,878)	139,995,536
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,874,878)	139,995,536

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	598893100.00	933721500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598893100.00	933721500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	525289100.00	905885100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	525289100.00	905885100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73500500.00	27836400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73500500.00	27836400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	593833817.00	806221974.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593833817.00	806221974.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593445951.00	806221974.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431087717.00	595543944.00
210101	Үндсэн цалин	346791923.00	401242924.00
210102	Нэмэгдэл	71581300.00	172756456.00
210104	Урамшуулал	12714494.00	21544564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54291400.00	68537780.00
210201	Тэтгэврийн даатгал	36918200.00	44888360.00
210202	Тэтгэмжийн даатгал	4343600.00	6165800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3474700.00	4189000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	868700.00	911800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8686200.00	12382820.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20946834.00	27336400.00
210301	Гэрэл, цахилгаан	3971563.00	7866400.00
210302	Түлш, халаалт	14483971.00	16520000.00
210303	Цэвэр, бохир ус	2491300.00	2950000.00
2105	Нормативт зардал	72845100.00	98655900.00
210502	Хоол, хүнс	72845100.00	98655900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2965000.00	500000.00
210604	Урсгал засвар	2965000.00	500000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	787400.00	1452100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	787400.00	1452100.00

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10522500.00	14195850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6067500.00	9839450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4455000.00	4356400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	387866.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	387866.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	387866.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5059283.00	127499526.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4174900.00	6837200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4174900.00	6837200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4174900.00	6837200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4174900.00	6837200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4174900.00	-6837200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	884383.00	120662326.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		780883.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	780883.00	121443209.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	146,882,958.00	1,270,835.92	592,856,271.65	741,010,065.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	146,882,958.00	1,270,835.92	592,856,271.65	741,010,065.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			139,995,535.58	139,995,535.58
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	146,882,958.00	1,270,835.92	732,851,807.23	881,005,601.15

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	934202400.00	813059174.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	934202400.00	813059174.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	934202400.00	813059174.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	698097800.00	595543944.00
210101	Үндсэн цалин	458288500.00	401242924.00
210102	Нэмэгдэл	217172500.00	172756456.00
210104	Урамщуулал	22636800.00	21544564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87387600.00	68537780.00
210201	Тэтгэврийн даатгал	59423500.00	44888360.00
210202	Тэтгэмжийн даатгал	6991200.00	6165800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5592900.00	4189000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1398400.00	911800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13981600.00	12382820.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27036400.00	27336400.00
210301	Гэрэл, цахилгаан	7866400.00	7866400.00
210302	Түлш, халаалт	16520000.00	16520000.00
210303	Цэвэр, бохир ус	2650000.00	2950000.00
2105	Нормативт зардал	98655900.00	98655900.00
210502	Хоол, хүнс	98655900.00	98655900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1452100.00	1452100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1452100.00	1452100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21072600.00	21033050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16716200.00	16676650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4356400.00	4356400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	933721500.00	933721500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	905885100.00	905885100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	905885100.00	905885100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27836400.00	27836400.00
132001	Орон нутгийн төсвөөс	27836400.00	27836400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		780883.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		121443209.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	39.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг. Цэцэрлэг нь “Боловсон хүчнийхээ бүтээмжийг дээшлүүлэх замаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээгээр тэргүүний цэцэрлэг болохыг эрмэлзэх”, “Тохилог орчин чанартай сургалт явуулах” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Боловсролын ерөнхий газраас сургалтын алба болон санхүүгийн материалд шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,7 сая төгрөгөөр буюу 18,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	780.9	121443.2	120662.4
Авлага	1314.5	1309.4	-5.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	32401.4	39722.6	7321.2
Үндсэн хөрөнгө	706513.2	719302.9	12789.7
Нийт хөрөнгө	741010.0	881778.1	140768.2
Өр төлбөр	0	772.5	772.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	741010.0	881005.6	139995.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	741010.0	881778.1	140768.2

Мөнгөн хөрөнгө оны эцэст 121,4 сая төгрөг үлдэгдэлтэй гарсан нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 32,4 сая төгрөг болж оны эхнээс 7,3 сая төгрөгөөр өссөн байна. Бусад хангамжийн материал 39,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 911,3 сая төгрөг болж өссөн нь үндсэн хөрөнгийн данс хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 41,5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 192,0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 881,0 сая төгрөг болж 139,9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 139,9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 905,9 сая, орон нутгийн төсвөөс 27,8 сая, нийт зарлагыг 933,7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 623.5 сая төгрөгөөр хянаж, 50.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 231.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 905.9 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 27.8 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 905.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 27.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 933.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 905.9 сая, орон нутгийн төсвөөс 27.8 сая нийтдээ 933.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 0.7 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 813.0 сая төгрөг буюу 87% хувьтай буюу дансанд 121.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	2178.2	2138.6	39.5	98.1%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	98655.9	98655.9	0	100%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4518.2	4518.2	0	100%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	2178.2	2178.2	0	100%
5	Боловсролын стандарт, сургалтын	505339.5	406608.6	98730.9	80.4%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	293796.0	271123.2	22672.8	92.2%
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	27836.4	27836.4	0	100%
	Нийт дүн	934502.4	813059.1	121443.2	87.0%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 121.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 102.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 18.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 131.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний захирал Б.Галымбек гүйцэтгэж, анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 616,7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 595.5 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн боловч төсөв, өмч, хөрөнгө зарцуулах тухай 1 тушаалаар гарсан 23,4 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 85%-тай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газраас тогтоосон цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг баримталж ажиллах, зөрчлийг арилгах зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	4,362.9	1	4,362.9	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	4,362.9	1	4,362.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 46,8 сая төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг нь цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 23,4 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	23,400.0					1	23,400.0				
Дүн	1	23,400.0					1	23,400.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах шийдвэрийг дансанд дутуу байршуулсан	1	23400,0					1	23400,0
Дүн	1	23400,0					1	23400,0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								